



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/238/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж мөрдөх.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А хороо 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/186
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ЮМЖИРДУЛАМ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		14,343,109.7	14,804,889.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	9,546,564.5	8,666,864.5
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	4,775,381.6	6,120,366.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	21,163.5	17,658.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		552,659.6	547,507.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	552,659.6	547,507.1
39200	Биет хөрөнгө		502,659.6	493,171.3
39300	Биет бус хөрөнгө	13	50,000.0	54,335.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		14,895,769.3	15,352,396.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		370,446.9	630,851.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	370,446.9	630,851.9
41300	Өглөг	17а, 17б	96,927.8	295,250.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	273,519.1	335,601.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		14,525,322.4	14,721,544.7
51	Засгийн газрын хувь оролцоо		14,525,322.4	14,721,544.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		287,580.0	287,580.0
51200	Хуримтлагдсан үр дүн		14,126,995.2	14,323,217.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		110,747.2	110,747.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		14,895,769.3	15,352,396.6

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	112,199,902.6	107,723,689.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	38,779,504.4	41,264,363.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	38,779,504.4	41,264,363.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,562.4	501,296.8
120	Нийтлэг татварын бус орлого	141,562.4	501,296.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	73,278,835.9	65,958,029.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	100,065,662.3	107,526,879.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,065,662.3	107,526,879.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,775.6	902,614.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	625,516.0	621,365.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,290.8	82,277.8

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,152.1	25,235.3
2104	Хангамж, бараа материалын зардал	26,660.2	29,021.8
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,996.1	9,733.0
2107	Томилолт, зочны зардал	2,542.9	2,542.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,234.3	81,781.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,383.2	50,656.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,181,886.7	106,624,264.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,134,240.3	196,810.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,134,240.3	196,810.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,345,526.4	0.0	2,345,526.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	45,555.7	0.0	45,555.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,391,082.1	0.0	2,391,082.1
9	Тайлант үеийн үр дүн	12,134,240.3	0.0	12,134,240.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,525,322.4	0.0	14,525,322.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,525,322.4	0.0	14,525,322.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-588.2	0.0	-588.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,524,734.1	0.0	14,524,734.1
19	Тайлант үеийн үр дүн	196,810.6	0.0	196,810.6
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	14,721,544.7	0.0	14,721,544.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	107,999,868.9	106,644,584.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	34,803,395.1	40,379,018.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	34,803,395.1	40,379,018.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	202,587.0	259,473.5
120	Нийтлэг татварын бус орлого	202,587.0	259,473.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,993,886.8	66,006,092.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,013,365.5	107,524,284.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,013,365.5	107,524,284.7

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,446.5	852,839.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	625,514.2	621,348.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,290.8	82,277.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,152.1	25,235.3
2104	Хангамж, бараа материалын зардал	30,514.4	29,703.8
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,396.1	9,500.0
2107	Томилолт, зочны зардал	2,542.9	2,542.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,377.2	80,230.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,658.9	2,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,194,919.0	106,671,445.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,986,503.4	-879,700.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	7,986,503.4	-879,700.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,560,061.1	9,546,564.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,546,564.5	8,666,864.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мян.төг/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,471,712,4	97,175,918,0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,471,712,4	97,175,918,0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,055,7	847,011,2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,481,1	621,348,9
210101	Үндсэн цалин	475,493,2	470,478,9
210102	Нэмэгдэл	111,867,9	120,085,2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,320,0	19,984,7
210104	Урамшуулал	10,800,0	10,800,0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,283,0	82,277,8
210201	Тэтгэврийн даатгал	57,423,8	56,928,0
210202	Тэтгэмжийн даатгал	6,214,8	6,335,4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,971,8	5,068,3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,243,0	1,267,1
210205	Эрүүл мэндийн даатгал	12,429,6	12,679,0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,066,3	25,235,2
210301	Гэрэл, цахилгаан	3,600,0	3,232,6
210302	Түлш, халаалт	18,986,3	18,986,3
210303	Цэвэр, бохир ус	3,480,0	3,016,4
2104	Хангамж, бараа материалын зардал	30,375,4	29,703,8
210401	Бичиг хэрэг	7,291,5	7,290,1
210402	Тээвэр, шатахуун	14,728,2	14,728,2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,655,7	2,314,6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,0	60,0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,0	5,310,9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,0	9,500,0
210604	Урсгал засвар	9,500,0	9,500,0
2107	Томилолт, зочны зардал	2,542,9	2,542,9
210702	Дотоод албан томилолт	2,542,9	2,542,9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,807,0	74,402,6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,706,0	61,339,3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,0	720,0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,0	1,000,0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,5	82,6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	154,0	154,0
210807	Газрын төлбөр	204,0	4,0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,874,5	11,102,7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,0	2,000,0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,0	2,000,0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,621,656,7	96,328,906,7
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,621,656,7	96,328,906,7
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	98,565,055,9	96,296,234,0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,0	7,495,9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,100,8	25,176,8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,471,712,4	34,565,751,7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,538,830,0	59,394,7
310001	Улсын төсвөөс санхүүжих	17,538,830,0	59,394,7
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,932,882,4	34,412,980,4
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	81,932,882,4	34,412,980,4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	93,376,5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	92,566,3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	810,2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	9,546,564,5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8,666,864,4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	105.00	101.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	50.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	44.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52.00	50.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	47.00	45.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Мян,тэг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285,0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285,0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, өр авлага, шилэн дансны зөрчилтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор Г.Мөнхбаяр, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

“Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт орж ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 17.4 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 456.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,546.56	8,666.86	(879.70)
Дансны авлага	4,775.38	6,120.37	1,344.98
Бараа материал	21.16	17.66	(3.50)
Үндсэн хөрөнгө	552.66	547.51	(5.15)
Биет бус хөрөнгө	50.00	54.34	4.34
Нийт хөрөнгө	14,895.77	15,352.40	456.63
Дансны өглөг	96.93	295.25	198.32

/сая.төгрөг/

-төрийн	-	287.58	287.58
Хуримтлагдсан үр дүн	14,127.00	14,323.22	196.22
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,895.77	15,352.40	456.63

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өнгөрсөн оноос 879.7 сая төгрөгөөр буурч 8,666.9 сая төгрөг болсон байна. Энэ нь дараа сарын эхэнд гарах төлбөрийн хэмжээгээр арилжааны банкин дахь харилцах дансанд 8,645.1 сая төгрөг, замд яваа мөнгөн хөрөнгө 21.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэгдлийг тулган баталгаажуулсан байна.

Авлага өнгөрсөн оноос 1,345.0 сая төгрөгөөр өсөж 6,120.3 сая төгрөг болсон байна. Хүснэгт 2. Материаллаг нөлөөлөл бүхий өөрчлөлтийг харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	569.7	691.9	122.2
Татаас, санхүүжилтийн авлага	4134.5	4978.6	844.1
Бусад авлага	71.1	449.7	378.6

Авлагын үлдэгдлийг ангилбал:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 679.3 сая төгрөг
2. Сайн дурын даатгуулагч эхийн шимтгэлийн авлага 4.7 сая төгрөг

Төлбөртэй үйлчилгээний авлага: 691.9 сая төгрөг

3. Ажил олгогчийн шимтгэлийн чөлөөлөлтөөс үүссэн улсын төсвийн санхүүжилтийн авлага 4765.6 сая төгрөг
4. Ажил олгогчийн дэмжлэгийн улсын төсвийн санхүүжилтийн авлага 213.0 сая төгрөг

Татаас, санхүүжилтийн авлага: 4,978.6 сая төгрөг

5. НДШ-ийн алданги торгуулийн авлага 8.0 сая төгрөг
6. Бусад авлага 449.7 сая төгрөгийн авлага байна.

Бусад авлага: 449.7 сая төгрөг

Төлбөртэй үйлчилгээний авлага 692.0 сая, татаас санхүүжилтийн авлага 4,978.6 сая, бусад байгууллагаас авах авлага 449.7 сая төгрөг байна. Авлагын үлдэгдлийг ангилан харуулав. Авлагыг тулган баталгаажуулсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр тогтоолт, тэтгэмж олголтын байдалд 2021 оны 11 сард хяналт шалгалт хийхэд тэтгэврийг илүү тогтоосон, тэтгэмжийг илүү тооцож олгосон зэрэг хувь хүнтэй хийх тооцооны 449.7 сая төгрөгийн авлага үүссэн зөрчил илэрсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 3.5 сая төгрөгөөр буурч 17.7 сая төгрөг болсон байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлтийг харуулбал:

1. Тайлант хугацаанд 27.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан,
2. НДЕГ-аас 3.2 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан.

Тайлант хугацаанд 34.0 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 0.1 сая төгрөгийн ашиглах эрхгүй болсон бараа материалыг НДЕГ-т шилжүүлсэн байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдлийг төрлөөр харуулбал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Бичиг хэрэг	1.1	2.2	1.1
Аж ахуйн материал	13.6	13.1	-0.5

Сэлбэг	0.7	0.5	-0.2
Түлш шатах тослох материал	0.07	0.1	0.03
Бусад хангамж	5.6	1.7	-3.9
Дүн	21.1	17.6	-3.5

Биет хөрөнгийн үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 159.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж 40.3 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлээр дансны үнэ буурсантай холбоотой байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Биет хөрөнгө:	502.7	493.2	-9.5
Барилга байгууламж	408.8	408.8	
Хуримтлагдсан элэгдэл	-18.3	-27.5	9.2
Авто тээврийн хэрэгсэл	69.9	20.9	-49.0
Хуримтлагдсан элэгдэл	-66.0		
Машин тоног төхөөрөмж	189.1	117.6	-71.5
Хуримтлагдсан элэгдэл	-115.2	-54.3	-60.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	67.4	67.4	
Хуримтлагдсан элэгдэл	-33.1	-39.9	6.8
Биет бус хөрөнгө:	50.0	54.3	4.3
Программ хангамж	3.2	4.5	1.3
Хуримтлагдсан элэгдэл	-3.2	-0.2	-3.0
Бусад биет бус хөрөнгө	50.0	50.0	
Нийт дүн	552.7	547.5	-5.2

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 4.5 сая төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3.2 сая төгрөгийн программ хангамжийг данснаас хасаж 3.2 сая төгрөгөөр дахин үнэлж орлогод авсан, 1.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд дансны өглөг 198.3 сая төгрөгөөр өсөж 295.2 сая төгрөг болсон нь нийгмийн даатгалын сангийн өглөгтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн өглөгийг хүснэгтээр харуулав.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат ер төлбөр	96.9	295.3	198.4	76.2
Урьдчилж орсон шимтгэлийн орлого	273.5	335.6	62.1	23.8
Дүн	370.4	630.9	260.5	100

“Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх” тухай Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажил олгогч, сайн дурын даатгуулагчдыг шимтгэлээс чөлөөлсний улмаас урьдчилж төлсөн шимтгэлийн орлогоор өглөг нэмэгдсэн байна. Үүнийг дараагийн онуудад төлөх шимтгэлд шилжүүлэн тооцохоор төлөвлөж байгаа юм байна. Богино хугацаат ер төлбөрийн өглөг нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн, данс андуурч төлсөн зэрэг өглөг үүссэнтэй холбоотой байна. Үүнийг дараа онд залруулж ер төлбөрийг барагдуулдаг байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 14,323.2 сая төгрөг болж 196.2 сая төгрөгөөр өссөн нь мөн нийгмийн даатгалын сангийн тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287.6	287.6		
Хуримтлагдсан үр дүн	14127.0	14323.2	196.2	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110.7	110.7		
Дүн	14525.3	14721.5	196.2	100

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагч нь 2021 төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 26,539.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 98,345.7 сая төгрөгөөр, татаасыг 71,806.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн орлогыг 45,277.7 сая төгрөгөөр, татаас санхүүжилтийн орлогыг 52,833.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 98,458.9 сая төгрөгөөр баталсан байна. Зөрүүг харилцах дансны өмнөх оны эхний үлдэгдлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын нэгдсэн сангаас санхүүжих 62,610.2 сая, улсын төсвөөс ажил олгогчийн төлөх шимтгэлийн чөлөөлөлт 59.4 сая төгрөгийн татаас санхүүжилтийг бүрэн олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 34,506.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн нийт 97,175.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна.

Орлого

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 27,738.9 сая төгрөг байсан бол гүйцэтгэлээр 34,565.8 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 125 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн орлогын төрөл тус бүрээр харуулбал:

/сая.төг/				
№	Орлогын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Төсөвт болон аанб-ын төлсөн шимтгэл	23635.2	26264.4	111.6
2	Цаатан иргэдийн шимтгэл	134.9	124.4	92.2
3	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нөхөн төлсөн шимтгэл		4570.6	
4	Сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэл	3258.0	3114.4	95.6
5	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлсөн шимтгэл	192.9	144.0	74.7
6	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлсөн шимтгэл	476.9	136.9	28.7
7	ҮОМШӨ-ний сангаас төлсөн шимтгэл	38.8	38.8	100
8	Бусад орлого	2.3	112.7	148
9	Улсын төсвөөс төлсөн шимтгэл		59.4	
	Нийт дүн	27,738.9	34,565.8	125

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Зардал

Үйл ажиллагааны нийт зардлын гүйцэтгэл 97,175.9 сая төгрөг буюу 97.7 хувьтай байгаагаас бараа ажил үйлчилгээний зардал 868.7 сая төгрөг буюу 97 хувьтай байна.

Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардал 96,307.2 сая төгрөг болж 2,269.5 сая төгрөг хэмнэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5-р зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогын дүнгээс дутсан зөрүүг төсөв хоорондын тооцооны орлогоор хаасан, төсвийн тайлангийн нийт зарлага мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагын зөрүү нь мөн төвлөрүүлсэн шилжүүлэг, хоорондын тооцоогоор хаагдсан байна. Дээд шатны төсөв болон доод шатны төсөв хооронд ихээхэн хэмжээний шилжүүлэг, төвлөрүүлэлт хийсэн, санхүүгийн тайлагналд өөр өөр санхүүгийн программ хангамж ашиглаж байгаа нь хоорондын тооцоог гаргах, хянахад хүндрэл учруулж байна. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тохируулгыг харна уу.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тохируулга

Хүснэгт 8

Орлогын дансны нэр	Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого		Нэмэлт санхүүжилтын тайлан орлого	Төсвийн тохируулгын дүн	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого
НДЕГ-ын санхүүжилт/сан/	65,051,500,000.00	65,051,500,000.00	-	65,051,500,000.00	-
НДЕГ-ын санхүүжилт/байгууллага/	894,913,200.00	894,913,200.00	-	26,200,733.52	868,712,466.48
Шимтгэлийн орлого	34,393,676,940.63	40,379,018,195.14	-	849,408,965.25	33,544,267,975.38
ЭМД-ын орлого	5,985,341,254.51		-	5,985,341,254.51	
ТҮАОрлого	810,100.00	810,100.00	-	-	810,100.00
Туслах ҮА-ны орлогын хүү	146.76	19,531,063.53	-	-	146.76
ЭМД-ын орлогын хүү	227,268.78		-	227,268.78	-
Шимтгэлийн дансны хүү	19,303,647.99		-	19,303,647.99	-
НДШ-ын алданги	7,655,544.40	239,132,358.45	-	-	92,566,318.40
Бусад орлого	225,254,525.14		-	141,023,040.05	
ЭМД-ын орлогын алданги	679,288.91		-	-	
Нэр данс зөрүү орлого	5,543,000.00		-	5,543,000.00	
Нэмэлт санхүүжилт/байгууллага/	285,000.00	285,000.00	285,000.00	-	-
Улсын төсвийн санхүүжилт/хөн гөлөлт, чөлөөлөлтийн орлого/	59,394,700.00	59,394,700.00	-	-	59,394,700.00
Хэлтсээс сумдад олгосон санхүүжилт	55,903,292,294.21	55,903,292,294.21		55,903,292,294.21	-

Нийт орлого	162,547,876,911.3 3	162,547,876,911.3 3	285,000.00	127,981,840,204.3 1	34,565,751,707.02
Зардалын дансны нэр	Мөнгөн гүйлгээний тайлангийн зардал		Нэмэлт санхүүжилтын тайлан зардал	Төсвийн тохируулгын дүн	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардал
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		621,348,881.00			621,348,881.00
Ажил олгогчийн НДШ		82,277,835.05			82,277,835.05
Байр ашиглалттай холбоотой тогтомол зардал		25,235,263.17			25,235,263.17
Хангамж бараа материалын зардал		29,703,790.98			29,703,790.98
Эд хогшил, урсгал засварын зардал		9,500,000.00			9,500,000.00
Томилолт, зочны зардал		2,542,900.00			2,542,900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		80,230,626.28	285,000.00	5,543,000.00	74,402,626.28
Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000.00			2,000,000.00
Бусад урсгал шилжүүлэг		96,477,147,038.44		148,240,329.12	96,328,906,709.32
Төвлөрүүлэх шилжүүлэг		10,167,287,356.33		10,167,287,356.33	-
		55,903,292,294.21		55,903,292,294.21	-
		26,200,733.52		26,200,733.52	-
		146.76		146.76	-
		810,100.00		810,100.00	-
Нийт зарлага		163,427,576,965.7 4	285,000.00	66,251,373,959.94	97,175,918,005.80
Эхний үлдэгдэл		9,546,564,513.24			
Эцсийн үлдэгдэл		8,666,864,458.83		61,730,466,244.37	62,610,166,298.78
		879,700,054.41		61,730,466,244.37	=62610166298.78

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын хэлтэс нэмэлт санхүүжилтийн дансаар НДЕГ-аас 0.3 сая төгрөг хүлээн авч зар сурталчилгааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал болох Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад нийт зардлыг 26.2 сая төгрөгөөр буюу 3 хувиар, цалин нэмэгдэл урамшууллын зардлыг 5 сая төгрөгөөр буюу 1,1 хувиар, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.8 сая төгрөгөөр буюу 3 хувиар тус тус хэмнэсэн байна.

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,272.9 сая төгрөгийн нийт 71 мэдээллээс 1,168.1 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 104.8 сая төгрөг буюу 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.3.6, 6.4.6, 6.4.5, 6.4.8, 6.8.1, заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн санхүүгийн тайлангийн иж бүрдлийг шалгахад мөрдөж байгаа санхүүгийн тайлангийн маягт УСНББОУС-1-ийн шаардлагыг бүрэн хангахгүй байна. Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тайланг бэлтгэх аргачлал тодорхойгүй, бичгээр үйлдсэн заавар байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Тайлант хугацаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар хувь хүнээс авах их хэмжээний авлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 7 зөвлөмж өгсөн. 2 зөвлөмж бүрэн хэрэгжиж, НДЕГ-аас батлан, мөрдөж байгаа “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж

ажиллах биелэлт 70 хувьтай, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглах нөөцийг судлан шийдвэрлүүлэх, өр, авлага барагдуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж мөрдөх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 104.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 104.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, НББ-ийн хуультай холбоотой 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар алдаа залруулагдаагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт гараагүй болно.

4.3 Албан шаардлага

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 104.8 сая төгрөгийн буюу 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.3.6, 6.4.6, 6.4.5, 6.4.8, 6.8.1, заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн хуультай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн заавар аргачлал тодорхойгүй, санхүүгийн тайлангийн стандарт маягыг бүрэн мөрддөггүй, санхүүгийн программаас ингэж гардаг гэсэн тайлбартай байгаа нь санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.